



**ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА  
(Барилгын ажил)**

Хэнд: Сонирхсон оролцогчдод (Зөвхөн Монголын дотоодын компаниудад)	Хугацаа: 2019 оны 3-р сарын 14
	Дугаар: RFQ-2019-001

Хүндэт Ноён / Хадагтай:

Бид та бүхнийг энэхүү үнийн санал ирүүлэх урилгын хавсралт 1-т заасан Улаанбаатар хотод байрлалтай Барилгын Хөгжлийн Төвийн Лабораторийн барилгын гадна хана, цонх, хаалга дулаалах засварын ажилд үнийн санал ирүүлэхийг урьж байна. Үнийн саналыг хавсралт 2-т хавсрагдсан маягтын дагуу бэлтгэж ирүүлнэ үү.

Үнийн санал ирүүлэх сонирхсон этгээдүүдэд засварын ажил гүйцэтгэх барилгатай газар дээр нь танилцах уулзалт 2019 оны 3-р сарын 27-ны өдрийн 10.00 цагт Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргийн 20-р хороо, Барилгын хөгжлийн төвийн лабораторийн байранд болно.

Үнийн саналыг Улаанбаатарын цагаар 2019 оны 4-р сарын 8-ны (Даваа гараг) 11:00 цагаас өмнө [bids.mn@undp.org](mailto:bids.mn@undp.org) имэйл хаягруу илгээх эсвэл доорх хаягаар хүргэж ирэх:

**НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр**  
НҮБ-ийн байр – 14201, НҮБ-ийн гудамж – 14, Сүхбаатар Дүүрэг  
Улаанбаатар, Монгол

**Имэйлээр илгээж буй файл 5МВ-аас хэтрэхгүй, вирус агуулаагүй байх шаардлагатай.**

Файл нь ямар нэг вирус агуулаагүй, гэмтээгүй байх шаардлагатай эс бөгөөс үнийн саналыг хүлээн авахгүй.

Үнийн саналыг дээр дурьдсан эцсийн хугацаанд эсвэл хугацаанаас өмнө ирүүлэх нь оролцогчийн хариуцлага байна. Ямар ч шалтгааныг үл харгалзан дурьдсан эцсийн хугацаанаас хоцорч ирсэн үнийн саналд НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр үнэлгээ хийхгүй. Хэрэв үнийн саналыг имэйлээр илгээж буй бол вирусгүй, гэмтээгүй, .pdf форматтай, гарын үсгээр баталгаажуулсан эсэхийг нягталана уу.

Дээр дурьдсан ажлыг хийж гүйцэтгэхэд дараах шаардлага, нөхцлүүд тавигдах болохыг анхаарна уу:

Тээврийн нөхцөл [INCOTERMS 2010] (Үнийн хуваарьт оруулна уу)	<input checked="" type="checkbox"/> DAP, Delivery at Place
Хил гаалийн хураамж /хэрэв шаардлагатай бол/ төлөх тал:	<input checked="" type="checkbox"/> Ханган нийлүүлэгч/Оролцогч

Хүргэлт хийх газрын дэлгэрэнгүй хаяг	Барилгын Хөгжлийн Төвийн Барилгын материалын сорил шинжилгээний лабораторын барилга Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо
Хүлээлгэн өгөх эцсийн хугацаа (хэрэв энэ хугацаанаас хэтэрвэл НҮБХХ татгалзаж болзошгүй)	2019 оны 6-р сарын 28 Баасан гариг
Хүлээлгэн өгөх хуваарь	<input checked="" type="checkbox"/> Шаардлагатай
Үнийн санал ирүүлэх валют	<input checked="" type="checkbox"/> Монгол Төгрөг (MNT)
Үнийн саналд НӨАТ тооцох эсэх	<input checked="" type="checkbox"/> НӨАТ болон бусад шууд бус татвар, хураамж, шимтгэлийг оруулж тооцсон байх
Ажил хүлээлгэн өгсөний дараах үйлчилгээ	<input checked="" type="checkbox"/> Техникийн туслалцаа (1 жилийн баталгаат хугацаатай)
Үнийн санал ирүүлэх эцсийн хугацаа	2019 оны 4-р сарын 8 Даваа гараг 11:00 цаг /Улаанбаатарын цагаар/
Бүх төрлийн бичиг баримт бэлтгэж ирүүлэх хэл (заавар, гарын авлага, каталоги г.м)	<input checked="" type="checkbox"/> Монгол хэл
Шаардлагатай бичиг баримтууд	<input checked="" type="checkbox"/> Бүрэн бөглөгдсөн маягт: Хавсралт 1-т заасан шаардлагуудын дагуу Хавсралт 2-т өгөгдсөн маягтыг бүрэн бөглөсөн байх; <input checked="" type="checkbox"/> Аж Ахуйн Нэгжийн Улсын Бүртгэлийн Гэрчилгээ; <input checked="" type="checkbox"/> Санхүүгийн болон Татварын тайлан; <input checked="" type="checkbox"/> Хараат бүс аудитын гарын үсэг, тамгаар баталгаажсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан (орлого, мөнгөн урсгал, тэнцэл) <input checked="" type="checkbox"/> Сүүлийн 3 жил тус бүр 100,000 ам. доллараас багагүй барилгын ажил гүйцэтгэсэн байх. <input checked="" type="checkbox"/> Сүүлийн 5 жилд хийж гүйцэтгэсэн ижил төстэй төслүүдийн жагсаалт гэрээний дүнгийн хамт, захиалагчийн холбоо барих хаягийг оруулсан байх. <input checked="" type="checkbox"/> Сүүлийн 5 жилд хийж гүйцэтгэсэн ижил төстэй 3-аас доошгүй ажлын гэрээ. <input checked="" type="checkbox"/> Хийж гүйцэтгэж буй төслүүдийн жагсаалт гэрээний дүнгийн хамт, захиалагчийн холбоо барих хаяг, төсөл тус бүрийн гүйцэтгэлийн хувь, гэрээний дуусах хугацаа зэргийг оруулсан байх. <input checked="" type="checkbox"/> Хийж гүйцэтгэсэн ижил төстэй 3 ажлын захиалагчаас амжилттай хийж гүйцэтгэсэн талаарх албан тодорхойлолт. <input checked="" type="checkbox"/> Оролцогч гэрээний хугацаа хожимдуулсан талаарх сүүлийн 5 жилийн мэдээлэл болон төлбөрийн хэмжээ, шийдвэрийн хамт <input checked="" type="checkbox"/> Төсөлд ашиглагдах материалын хүснэгтэн мэдээлэл. НҮБХХ нь үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг оролцогчоос гаргуулан авах эрхтэй. Цаашлан шаардлагатай мэдээллийг гаргаж өгөөгүй эсвэл шаардлагад нийцээгүй мэдээлэл хүргүүлсэн оролцогчийг шаардлага хангахгүй гэж үзэх эрхтэй. <input checked="" type="checkbox"/> Гадна фасад шинэчлэх, гадна хана дулаалах чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай барилгын инженер, 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай барилгын даамал ажиллуулах боломжтой байх. <ul style="list-style-type: none"> <li>• Ажилтнуудын товч намтарын (CV) хуулбарыг үнийн саналтай хамт өгөх шаардлагатай</li> </ul>

	<p><input checked="" type="checkbox"/> Материал, тоног төхөөрөмжийг аюулгүй талбайд хадгалах боломжтой байх.</p> <p><input checked="" type="checkbox"/> Гэрээт гүйцэтгэгч дараах тоног төхөөрөмж, машин механизмыг эзэмшдэг эсвэл түрээслэх талаар баталгаа өгөх: авто кран, цахилгаан дрилл, будаг шүршигч</p> <p><input checked="" type="checkbox"/> Хийж гүйцэтгэх ажил болон багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал, хүн хүчний графикийг багтаасан ажлын төлөвлөгөө (цаасаар, файлаар)</p> <p><input checked="" type="checkbox"/> Гэрээт гүйцэтгэгч талбайн хамгаалах хэрэгсэл (каска, ажлын гутал, ажлын хантааз)-ийг багтаасан ХАБЭА-н зааварчлага, журам хүргүүлэх, аливаа төрлийн осол аваариас сэргийлэх зорилгоор барилгын талбайг ажлын дохио, тэмдэглэгээ, анхааруулах тэмдэг, аюулгүйн хаалт, хамгаалалтын тороор байнга тоноглоно.</p> <p><input checked="" type="checkbox"/> НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267/1989 жагсаалт, НҮБ-ын Худалдан Авах Ажиллагааны Хэлтсийн жагсаалт болон бусад НҮБ-ын хориглосон жагсаалтанд багтаагүй гэдгийг бичгээр мэдүүлэх.</p>
<i>Илгээсэн өдрөөс эхлэн үнийн санал хүчинтэй байх хугацаа</i>	<p><b>120 өдөр</b></p> <p>Шаардлагатай тохиолдолд НҮБХХ гэрээт гүйцэтгэгчээс үнийн саналын хүчинтэй байх хугацааг сунгах эрхтэй. Хүчинтэй хугацааны сунгалтыг гэрээг гүйцэтгэгч бичгээр ирүүлэх ба үнийн саналд өөрчлөлт орохгүй.</p>
<i>Үнийн санал хэсэгчлэн ирүүлэх</i>	Зөвшөөрөхгүй
<i>Төлбөрийн нөхцөл</i>	<p><input checked="" type="checkbox"/> Төлбөрийн валют нь Төгрөг бөгөөд төлбөрийг доорх нөхцөлөөр хийнэ:</p> <p><b>1 дэх төлбөр: 40%-ийг</b> барилгын материалын худалдан авалт, тэдгээрийг баталгаажуулсан баримт ирүүлснээр төлнө.</p> <p><b>2 дах төлбөр: 50%-ийг</b> барилгын засварын бүх ажил гүйцэтгэсэн, гарын үсгээр баталгаажуулсан ажил хүлээлгэсэн акт ирүүлснээр төлнө.</p> <p><b>3 дах төлбөр: 10%-ийг</b> ажил хүлээлгэн өгсөн актанд гарын үсэг зурсан өдрөөс хойш баталгаат хугацааны 4 (дөрвөн) сар өнгөрсөний дараа төлнө.</p> <p>Төлбөр тус бүрт, гүйцэтгэгч дараах зүйлсийг бүрдүүлж өгнө:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 11-ээр заалт Төслийн Тайлагналын А зүйлд заасан бичиг баримтууд</li> <li>- Үл тохирол илрээгүй байх</li> <li>- Ажлын тоо хэмжээний дагуу гүйцэтгэлийн одоогийн хувийг ажилбар тус бүрээр мөн сүүлийн төлбөрт ноогдох гүйцэтгэлийн өмнөх хувь, гүйцэтгэлийн одоогийн болон өмнөх хувь хэмжээний өөрчлөлт, ажилбар тус бүрийн төлөгдөх үнийн дүн зэргийг харуулах</li> <li>- Дээрх бүгд гүйцэтгэгчийн тамгаар баталгаажсан байх</li> <li>- Аливаа төлбөр бичиг баримтын бүрдлийн дагуу хийгдэнэ</li> <li>- Төлбөр хийхээр заагдсан ажлуудыг Демо Зөвлөх баталгаажуусан байна</li> </ul> <p>Гэрээт гүйцэтгэгчийн төлбөрийг төсөв болон ажлын тоо хэмжээнд үндэслэнэ.</p>
<i>Гүйцэтгэлийн Баталгаа</i>	<p><input checked="" type="checkbox"/> Шаардлагатай</p> <p><u>Хэмжээ:</u> Гэрээний үнийн дүнгийн 10%</p> <p><u>Хүчинтэй хугацаа:</u> Гүйцэтгэлийн баталгаа нь ажил дуусгах хугацаа, ажлын доголдол арилгах хугацаанд хүчин төгөлдөр байна</p> <p><u>Маягт:</u> Хавсралтаар өгөгдсөн Гүйцэтгэлийн Баталгааны Маягтыг харах</p>
<i>Хугацааны хоцрогдол</i>	<p>Дараах нөхцөлүүд ноогдуулна:</p> <p>Хугацаа хоцорсон хоног тутамд ноогдох гэрээний үнийн дүнгийн хувь: <b>0.5%</b></p> <p>Хугацааны хоцрогдолын дээд хэмжээ: <b>Нэг долоо хоног</b></p> <p>Авах арга хэмжээ: <b>Гэрээ цуцлах</b></p>
<i>Хариуцлагын даатгал</i>	Хариуцлагын даатгалын хамгийн доод хэмжээ тохиолдол бүрт 250,000 ам.доллараас доошгүй байх, бүхэлдээ хязгааргүй.

<p>Үнэлгээний шалгуур үзүүлэлт</p>	<p><input checked="" type="checkbox"/> 5-аас доошгүй жил барилгын гадна фасад шинэчилсэн, гадна хана дулаалсан ажлын туршлагатай байх</p> <p><input checked="" type="checkbox"/> Сүүлийн 3 жил тус бүр 100,000 ам. доллараас багагүй барилгын ажил гүйцэтгэсэн байх</p> <p><input checked="" type="checkbox"/> Сүүлийн 5 жилд 3-аас доошгүй ижил төстэй төсөл гүйцэтгэсэн байх</p> <p><input checked="" type="checkbox"/> Ижил төстэй 3 төслийн захиалагчаас амжилттай хийж гүйцэтгэсэн талаарх албан тодорхойлолт</p> <p><input checked="" type="checkbox"/> Төсөлд ашиглагдах материалын хүснэгтэн мэдээлэл</p> <p><input checked="" type="checkbox"/> Гадна фасад шинэчлэх, гадна хана дулаалах чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай барилгын инженер, 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай барилгын даамал ажиллуулах боломжтой байх</p> <p style="padding-left: 40px;">– Ажилтнуудын товч намтарын (CV) хуулбар</p> <p><input checked="" type="checkbox"/> Материал, тоног төхөөрөмжийг аюулгүй талбайд хадгалах боломжтой байх</p> <p><input checked="" type="checkbox"/> Гэрээт гүйцэтгэгч дараах тоног төхөөрөмж, машин механизмыг эзэмшдэг эсвэл түрээслэх талаар баталгаа өгөх: авто кран, цахилгаан дрилл, будаг шүршигч</p> <p><input checked="" type="checkbox"/> Хийж гүйцэтгэх ажил болон багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал, хүн хүчний графикийг багтаасан тодорхой, дэлгэрэнгүй ажлын төлөвлөгөөг цаасаар, файлаар өгөх</p> <p><input checked="" type="checkbox"/> Төслийн талбайд ХАБЭА-н шаардлагыг хангах</p> <p><input checked="" type="checkbox"/> Үнийн санал ажлын даалгаварыг бүрэн хамарсан байх</p> <p><input checked="" type="checkbox"/> Гэрээний Ерөнхий Нөхцлийг бүрэн хүлээн зөвшөөрсөн байх</p> <p><input checked="" type="checkbox"/> Гэрээт гүйцэтгэгч талбайн хамгаалах хэрэгсэл (каска, ажлын гутал, ажлын хантааз)-ийг багтаасан ХАБЭА-н зааварчлага, журам хүргүүлэх, аливаа төрлийн осол аваариас сэргийлэх зорилгоор барилгын талбайг ажлын дохио, тэмдэглэгээ, анхааруулах тэмдэг, аюулгүйн хаалт, хамгаалалтын тороор байнга тоноглоно.</p>
<p>НҮБХХ эрх олгоно:</p>	<p><input checked="" type="checkbox"/> Зөвхөн нэг ханган нийлүүлэгч</p>
<p>Гэрээний төрөл</p>	<p><input checked="" type="checkbox"/> Барилгын ажил гүйцэтгэх гэрээ</p>
<p>Гэрээний Тусгай Нөхцөл</p>	<p><input checked="" type="checkbox"/> Хэрвээ гүйцэтгэл нэг долоо хоногоор хоцорвол гэрээ цуцлах</p>
<p>Төлбөр шилжүүлэх нөхцөл</p>	<p><input checked="" type="checkbox"/> Шаардлагатай ажлыг амжилттай гүйцэтгэсэн</p> <p><input checked="" type="checkbox"/> Шалгалт</p> <p><input checked="" type="checkbox"/> НҮБХХ-ийн зөвшөөрөл</p>
<p>Үнийн саналын урилгын хавсралтууд</p>	<p><input checked="" type="checkbox"/> Ажлын хамрах хүрээ (Хавсралт 1)</p> <p><input checked="" type="checkbox"/> Үнийн санал ирүүлэх маягт (Хавсралт 2)</p> <p><input checked="" type="checkbox"/> Ерөнхий Нөхцөлүүд / Тусгай Нөхцөлүүд (Хавсралт 3)</p> <p><input checked="" type="checkbox"/> Гүйцэтгэлийн Баталгааны маягт (Хавсралт 4)</p> <p>Ерөнхий нөхцөлүүдийг хүлээн аваагүй тохиолдолд худалдан авах ажиллагааны процессийн шаардлага хангаагүй гэж үзнэ.</p>
<p>Лавлах ажилтаны холбогдох хаяг (зөвхөн бичгээр лавлана уу)</p>	<p>НҮБХХ Худалдан авах ажиллагааны нэгж, <a href="mailto:Bids.mn@undp.org">Bids.mn@undp.org</a></p> <p>НҮБХХ хугацаа сунгах шаардлагатай гэж үзэн Оролцогчдод шинэ эцсийн хугацааг мэдээлээгүй бол НҮБХХ хариу хоцроосон нь эцсийн хугацааг сунгах шалтгаан болохгүй.</p>
<p>Ирүүлэх үнийн саналын хуулбар</p>	<p>Сканнердсан бичиг баримтыг гарын үсгээр бүрэн баталгаажуулан <a href="mailto:bids.mn@undp.org">bids.mn@undp.org</a> хаягт <b>RFQ-2019-001</b> гэж гарчиглан цахимаар илгээнэ үү.</p>

Санал болгож буй ажлуудыг хянахдаа НҮБХХ-ийн шаардлагуудыг тайлбарласан хавсралтуудад заагдсан тодорхойлолтуудад нийцсэн эсэх, бүрэн хангасан зэргийг харгалзана.

Техникийн тодорхойлолт, шаардлагууд мөн бусад үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг хангасан, хамгийн бага үнэ санал болгосон үнийн санал сонгогдоно. Шаардлага хангаагүй аливаа үнийн саналаас татгалзана.

Нэгж үнэ нийт үнийн хооронд зөрүү гарвал НҮБХХ дахин тооцоолж (нэгж үнийг тоо хэмжээгээр үржүүлнэ) үзнэ. Нэгж үнэд үндэслэн нийт үнийг засварлана. Хэрэв ханган нийлүүлэгч НҮБХХ-ийн алдааг залруулан дахин тооцоолсон үнийг эцсийн гэж хүлээн зөвшөөрөхгүй бол үнийн саналаас татгалзана.

НҮБХХ үнийн саналыг хүлээн авсанаас хойш түүний хүчинтэй хугацаанд аливаа үнийн өсөлт, инфляци, валютын ханшны өөрчлөлт болон бусад зах зээлийн хүчин зүйлсийг хүлээн зөвшөөрөхгүй. Гэрээ байгуулах эсвэл Бараа нийлүүлэх эрх олгох үедээ нэгж үнэ болон нөхцөл, шаардлагуудад өөрчлөлт оруулахгүйгээр НҮБХХ ажлын тоо хэмжээг нийт саналын 25% хүртэлх хэмжээнд өсгөх эрхтэй.

Энэхүү Үнийн санал илгээх урилгын дагуу шалгарсан гүйцэтгэгчтэй хавсралтаар өгөгдсөн Ерөнхий Нөхцөлийн дагуу гэрээ хийгдэнэ. Үнийн санал илгээсэн нь гүйцэтгэгч НҮБХХ-ийн Ерөнхий Нөхцөлийг /Хавсралт 4/ асуултгүй хүлээн авсан гэж ойлгоно.

НҮБХХ нь сонгон шалгаруулалтын хэлбэр, үр дүнгээс үл хамааран аливаа үнийн саналыг хүлээн авах, гэрээ байгуулах/бараа нийлүүлэх эрх олгох, ханган нийлүүлэгчийн үнийн санал бэлтгэх, илгээхэд гарсан аливаа зардалд хариуцлага хүлээх үүрэггүй.

Өрсөлдөөнт сонгон шалгаруултын дагуу гэрээ байгуулах эсвэл бараа нийлүүлэх эрх олгогдоогүй хувь хүн, аж ахуйн нэгж НҮБХХ-ийн нийлүүлэгчийг хамгаалах журмын дагуу гомдол гаргах боломжтой байдаг гэдгийн анхаарна уу.

Хэрэв танд шудрага бус хандсан гэж үзвэл доорх холбоосноос нийлүүлэгчийг хамгаалах журмын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг авна уу: <http://www.undp.org/procurement/protest.shtml> .

Хэрэв та болон танай байгууллага, танай ажилтан тус үнийн саналын урилгад ашиглагдсан шаардлага, зураг, техникийн тодорхойлолт, зардлын тооцоо болон бусад мэдээллийг бэлтгэхэд оролцсон бол ашиг сонирхлын зөрчилөөс сэргийлэх, зайлсхийх зорилгоор мэдэгдэхийг НҮБХХ дэмжинэ.

Залилан, хориглосон үйл ажиллагаа, НҮБХХ-ийн эсрэг чиглэсэн үйл ажиллагаа мөн НҮБХХ-ийн үйл ажиллагаанд оролцогч гуравдагч талууд зэрэгт үл тэвчих бодлого хэрэгжүүлдэг. НҮБХХ нь ханган нийлүүлэгчдийг НҮБ-ын Ханган Нийлүүлэгчийн Дүрэм мөрдөхийг шаарддаг. Доорх холбоосоор орно уу: [http://www.un.org/depts/ptd/pdf/conduct\\_english.pdf](http://www.un.org/depts/ptd/pdf/conduct_english.pdf)

## Хавсралт 1-1. АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

№	Ажлын төрөл	Тайлбар	Нийт талбай, м <sup>2</sup>			
<b>ЦОНХ</b>						
1	Гадна агаартай шууд харьцах	385.65 м <sup>2</sup>	Урд зүг	Хойд зүг	Бар/зүг	Зүүн зүг
			153.18м <sup>2</sup>	168.02м <sup>2</sup>	60.34м <sup>2</sup>	4.11м <sup>2</sup>
<b>ГАДНА ШИЛЭН ХААЛТ, ХААЛГА</b>						
2	Металл рамтай шилэн	44.17 м <sup>2</sup>	3.17м <sup>2</sup>	37.83м <sup>2</sup>	15.3м <sup>2</sup>	3.17м <sup>2</sup>
<b>ГАДНА ХААЛГА</b>						
3	Дулаалгатай металл хаалга	19.63 м <sup>2</sup>	-	2.12м <sup>2</sup>	6.94м <sup>2</sup>	3.62м <sup>2</sup>
<b>ФАСАД</b>						
4	Өнгөлгөөний төрөл		Код	Талбай, м <sup>2</sup>	Тоо хэмжээ	
	1	Улбар хүрэн өнгийн чулуун хавтанцар	-	19.52	710.80 м <sup>2</sup>	
	2	Саарал өнгийн фасадын эмульс	RAL 7000	450.30		
	3	Саарал өнгийн фасадын эмульс	RAL 7012	14.55		
	4	Улбар хүрэн өнгийн чулуун хавтан	RAL 8002	14.48		
	5	Өнгөлгөөний фактуртай эмульс	RAL 8002	153.62		
	6	Улбар хүрэн өнгийн дээвэр /саравч/	RAL 8002	58.33		
<b>ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ</b>						
5	“А” блок, D` тэнхлэгийн дагуу (газрын төвшингөөс доош 1.0 м)			24.968 м <sup>3</sup>	215.526 м <sup>3</sup>	
	“А” блок, 1 тэнхлэгийн дагуу (газрын төвшингөөс зоорийн шал хүртэл)			49.036 м <sup>3</sup>		
	“А” блок, 7 тэнхлэгийн дагуу (газрын төвшингөөс зоорийн шал хүртэл)			12.036 м <sup>3</sup>		
	“С” блок, 1 тэнхлэгийн дагуу (газрын төвшингөөс зоорийн шал хүртэл)			25.804 м <sup>3</sup>		
	“С” блок, А тэнхлэгийн дагуу (газрын төвшингөөс зоорийн шал хүртэл)			65.822 м <sup>3</sup>		
	“С” блок, 6 тэнхлэгийн дагуу (газрын төвшингөөс зоорийн шал хүртэл)			37.86 м <sup>3</sup>		
<b>ЗООРИЙН ДАВХРЫН ДУЛААЛГА ХИЙГДЭХ ТАЛБАЙ</b>						
6	“А” блок, D` тэнхлэгийн дагуу (дамнурууны чихнээс доош 1.780 м)			64.93 м <sup>2</sup>	431.06 м <sup>2</sup>	
	“А” блок, 1 тэнхлэгийн дагуу (дамнурууны чихнээс зоорийн шал хүртэл)			72.81 м <sup>2</sup>		
	“А” блок, 7, 7` тэнхлэгийн дагуу (дамнурууны чихнээс зоорийн шал хүртэл)			71.68 м <sup>2</sup>		
	“С” блок, 1, 6 тэнхлэгийн дагуу (дамнурууны чихнээс зоорийн шал хүртэл)			102.18 м <sup>2</sup>		
	“С” блок, А тэнхлэгийн дагуу (дамнурууны чихнээс зоорийн шал хүртэл)			119.46 м <sup>2</sup>		
<b>1-Р ДАВХРААС ТЕХНИКИЙН ДАВХАР ХҮРТЭЛ ДУЛААЛГА ХИЙГДЭХ ТАЛБАЙ</b>						
7	“А” блок, 7 тэнхлэгийн дагуу				384.00 м <sup>2</sup>	
	“А” блок, 7` хуучин дулаалгыг хуулж авах (1,4,5, техникийн давхар)				268.80 м <sup>2</sup>	
8	ХАЯАВЧ ЦУТГАХ АЖИЛ (“А”, “С” блокын периметрийн ажил)				130.02 м <sup>2</sup>	

## Хавсралт 1-2. ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

“**БАРИЛГЫН ХИЙЦ БҮТЭЭЦИЙН СОРИЛ ШИНЖИЛГЭЭНИЙ БАРИЛГА**” нь нийт 3 блок барилгуудаас бүрдэнэ. “А” блок тэнхлэгээрээ 33.12м\*18.12м хэмжээтэй, зорьтой 5 давхар оффис, лабораторийн барилга, “В” блок тэнхлэгээрээ 29.2\*24.00м хэмжээтэй, зорьтой 15м өндөртэй лабораторийн туршилтын үндсэн дан барилга. “С” блок тэнхлэгээрээ 29.8\*12.00м хэмжээтэй, хагас газар доор, ашиглалттай дээвэртэй лабораторийн туслах хэсгийн барилга болно. Засварын ажлын зураг төслөөр тус барилгын зорь, “А” блокын 7” тэнхлэгийн дагуух гадна ханын дулаалга, шилэн багц буюу цонх, гадна хаалга, фасадны ажил, гадна шат, довжоо, пандус хаяавчийн цутгалтын ажил хийгдэнэ.

### **Зоорийн хана:**

Зоорийн давхрын гадна ханыг зурагт үзүүлсний дагуу гадна талаас нь дулаалах бөгөөд ингэхдээ “А” блокын D, D’ тэнхлэгийн дагуух зоорийн ханыг газрын төвшнөөс доош 1 метрээс багагүй гүнд, бусад ханыг зоорийн шал хүртэл XPS дулаалгын хавтангаар зурагт үзүүлсэний дагуу дулаална.

**1-р давхрын гадна хана:** 1-р давхарын гадна ханын дулаалгыг шинэчлэхдээ хуучин дулаалгыг нь хуулж аван ханын нийт гадаргуунд шавардлаган тэгшилгээ хийж (зөвшөөрөгдөх хүлцэл  $\pm 10$ мм) ханын нүх сүв, зай завсар, заадсыг зориулалтын материалаар сайтар чигжсэний дараа 150мм зузаантай полистрол (EPS) хавтанг цавуут зуурмагаар наан зориулалтын дюбелээр бэхэлнэ. Өнгөлгөөг тортой шавардлага хийн фасадны тодорхойлолтонд заасан будгаар будна.

### **1-5-р давхрын гадна хана:**

“А” блокын 7” тэнхлэгийн дагуух гадна ханын дутуу хийгдсэн хуучин дулаалгын хөөсөнцөр хавтанг хуулж аван шинээр  $b=150$  мм зузаантай EPS хавтангаар дулаална. Ингэхдээ ханын нийт гадаргуунд шавардлаган тэгшилгээ хийж (зөвшөөрөгдсөн хүлцэл  $\pm 10$ мм), ханын нүх сүв, зай завсар, заадсыг зориулалтын материалаар сайтар чигжсэний дараа 150мм зузаантай полистрол цавуут зуурмагаар наан зориулалтын дюбелээр бэхэлнэ. Өнгөлөг тортой шавардлага хийн фасадны тодорхойлолтонд заасан будгаар будна. Барилгын гадна хананд хийх хөөсөнцөр дулаалгыг “Барилгын дулаан тусгаарлах материал, хөөсөн полистрол (EPS) бүтээгдэхүүн, Техникийн шаардлага-MNS EN 13163-2011” стандартын дагуу хийж гүйцэтгэх бөгөөд 65мм, 65мм-ийн зузаантай 2 үетэйгээр зөрүүлэг хийн гүйцэтгэнэ.

### **Цонх:**

“Барилгын хуванцар (PVC) цонх, хаалганд тавигдах техникийн шаардлага-MNS 5830-2007” стандартын дагуу хийж угсрах бөгөөд рам нь  $b=75-80$  мм зузаантай, 6-8 камер буюу хөндийтэй, 3 давхар шиллэгээтэй, EPDM жийргэвч резинтэй, усны хаялагтай, нугас нь энгийн болон 2 ажиллагаатай байхаас гадна хуванцар вакум цонхыг зориулалтын амалгаа бэхлэгч ба тавцанг захиалж хийлгэнэ. Метал рамтай шилэн хана, хаалгыг угсрахдаа MNS 6266:2011-т заасан техникийн шаардлагыг хангаж ажиллана.

Ханын бүтэц, хэсэглэлийг БА-23-24 хуудаснаас, ханын дулаалга, бэхэлгээ, хаалга цонхны хэсгийг дулаалах схемийг БА-25-26 хуудаснаас үзнэ. Гадна хаалга, цонхны нэгдсэн түүврийг БА-2, хаалга цонхны схем, техникийн ерөнхий шаардлагыг БА-3-аас үзнэ.